



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 11 сарын 16 өдөр

Дугаар 12

Сүхбаатар

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1, 19 дүгээр зүйлийн 19.1, 36 дугаар зүйлийн 36.1.2-ийн "д" Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.1, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас ТОГТООХ нь:


1.Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн хавсралт ёсоор баталсугай.

2.Хөтөлбөрийг сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг иргэд, олон нийтийн оролцоонд тулгуурлан, нарийвчилсан төлөвлөгөө гарган зохион байгуулж, хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, ард иргэдэд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Ш.Оргил/-д үүрэг болгосугай.

3.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тус хуралдаанд бодлогын хороодоос оруулсан санал, дүгнэлтийг судлаж нягтлан хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд боловсруулах бодлогын бусад баримт бичиг, ажил, арга хэмжээнд тусган ажиллахыг аймгийн Засаг дарга /Ш.Оргил/-д даалгасугай.

4.Хөтөлбөрийн зорилтуудыг хэрэгжүүлэх идэвх, санаачлагатай ажиллахыг аймгийн бүх шатны нутгийн удирдлагын байгууллагуудад даалгаж, нийт иргэд, аж ахуйн нэгжүүдэд уриалсугай.

ДАРГА  БАЯМБАА



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

Нэг. ТОГТВОРТОЙ ЭДИЙН ЗАСАГ, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1.1. Хөдөө аж ахуйн бодлого, шинэчлэлийн хүрээнд:

Цаг уурын өөрчлөлтөд дасан зохицсон цогц, ухаалаг хөдөө аж ахуйг хөгжүүлж эрүүл, аюулгүй хүнсний хангамжийг сайжруулна.

1.1.1.Сэлэнгэ аймгийг “Эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг хослуулан эрхлэх стратегийн бүс нутаг” болгоно.

1.1.2.Таримал ургамлын үр үржүүлгийн аж ахуйг бүс нутгийн онцлогтой уялдуулан хөгжүүлж, нутагшсан сортын дээд үржүүлгийн үрийн хангамжийг 85.0 хувьд хүргэж, га-аас авах ургацын хэмжээг тогтворжуулна.

1.1.3.Тариалангийн талбайг газрын чанарын улсын хянан баталгаанд хамруулах ажлыг зохион байгуулна.

1.1.4.Ургамал хамгааллын цогц арга хэмжээг төлөвшүүлж, бордооны хангамжийг 50 хувьд, тэг элдэншүүлгийн технологийг нутагшуулж тариалангийн талбайн 85 хувьд нэвтрүүлж, хөрсний шим тэжээлт чанарыг нэмэгдүүлнэ.

1.1.5.Усны хайгуул, судалгаанд үндэслэн дэвшилтэт техник, технологи бүхий услалтын систем шинээр бий болгож, ашиглалтыг сайжруулах арга хэмжээ авна.

1.1.6.Өвлийн болон нарлаг хүлэмжийн аж ахуй эрхлэхийг дэмжиж, шинэ ургацын ногооны хангамжийг 25 хүртэл хувиар нэмэгдүүлнэ.

1.1.7.“Сэлэнгэ төмс, хүнсний ногоо” хөтөлбөр хэрэгжүүлэн авах ургацын хэмжээг 85.0 мянган тн-д хүргэнэ.

1.1.8.Жимс, жимсгэний нэр төрөл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, чацарганы үйлдвэрлэлийн нэгдсэн сүлжээ байгуулан, хүн амыг амин дэм бүхий жимс, жимсгэнээр ханган экспортын орлогыг нэмэгдүүлнэ.

1.1.9.Төмс, хүнсний ногоо хадгалах зориулалт бүхий стандартад нийцсэн зоорийг шинээр барихад дэмжлэг үзүүлж, хадгалах хэмжээг одоогийнхоос 20.0 мянган тн-оор нэмэгдүүлнэ.

1.1.10.“Ургацын баяр” уламжлалт арга хэмжээг тухайн жилд нэгж га талбайгаас хамгийн өндөр ургац хураасан суманд зохион байгуулна.

1.1.11.Нөөцөд түшиглэсэн органик бордооны дэвшилтэт технологи бүхий үйлдвэрлэлийг бий болгож, бордооны хангамжийг 1200 тн-оор нэмэгдүүлнэ.

1.1.12.Малчид, мал бүхий иргэдийн эрсдлийг даван туулах чадавхийг дээшлүүлж, сайн малчдын арга, туршлагыг нэвтрүүлнэ.

1.1.13.“Монгол мал үндэсний хөтөлбөр-2”-ийн хүрээнд малыг бүртгэлжүүлж, түүхий эд бэлтгэлийн “Гарал үүслийн бүртгэлийн нэгдсэн систем”-ийг нэвтрүүлнэ.

1.1.14. Малын бүрэн найрлагат тэжээлийн үйлдвэрийг бүсчилэн байгуулах, мал бордох үйл ажиллагаа эрхлэхийг дэмжиж, өвс тэжээлийн аюулгүй нөөцийг бүрдүүлнэ.

1.1.15. Бэлчээр, хадлангийн талбайн төлөв байдалд тохируулан зохистой ашиглах, сэргээн сайжруулах, хамгаалахад малчдын бүлгүүдийн идэвх санаачилгыг дэмжиж, эрсдлийг бууруулна.

1.1.16. Эрчимжсэн, хагас суурин мал аж ахуй эрхлэх бүс нутгийг шинэчлэн тогтоож, “Эрчимжсэн үхрийн аж ахуй” хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, мах, сүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

1.1.17. Малчид, мал бүхий иргэдийн эрэлт хэрэгцээнд нийлүүлэн, өндөр ашиг шимт малын гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийх, хээлтүүлэгчээр хангах арга хэмжээ авч, өндөр ашиг шимт малын тоог 10.0 мянган толгойгоор нэмэгдүүлнэ.

1.1.18. Мал эмнэлгийн технологит үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад малчдын оролцоог нэмэгдүүлэх, төрийн хяналтыг чангатгах, малын эмч нарын мэдлэг чадвар, хариуцлагыг өндөржүүлэн, мал эмнэлгийн лабораторийг шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангаж, чадваржуулна.

1.1.19. Мал амьтны өвчний танадалт, хяналт, үйлчилгээний технологид олон улсын ISO 17025 стандартыг нэвтрүүлж, махыг экспортод гаргах эрүүл ахуйн зохистой орчинг бүрдүүлнэ.

1.1.20. Мал, амьтныг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг малчдын идэвх оролцоотойгоор зохион байгуулж, “Эрүүл малтай” аймаг болно.

1.1.21. Хүнсний бүтээгдэхүүний бэлтгэл, боловсруулалт, хадгалалт, тээвэрлэлт, борлуулалтын тогтолцоог төлөвшүүлж, хүнсний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн цахим санг бий болгож, иргэдийн эрүүл, баталгаат хүнс хэрэглэх нөхцлийг бүрдүүлнэ.

1.1.22. Гахай, шувуу, зөгий, загасны аж ахуй хөгжүүлэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн, бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, нийлүүлэлтийг нэмэгдүүлнэ.

1.2. Байгаль орчны бодлого, шинэчлэлийн хүрээнд:

Байгалийн унаган төрх, тэнцвэрт байдлыг хадгалж, зохистой ашиглах, нөхөн сэргээх боломжийг бүрдүүлэн, байгалийн нөөц баялгийг эдийн засгийн өсөлт, нийгмийн тогтвортой хөгжлийн үндэс болгоно.

1.2.1. Ойн нөөцийг хамгаалах, үр өгөөжтэй ашиглах, нөхөн сэргээх, мэргэжлийн байгууллагуудын менежментийг сайжруулах, ойн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлж, жил бүр 2000-аас доошгүй га талбайд ойжуулалт хийнэ.

1.2.2. Томоохон төв суурин газрын агаар, ус, хөрсний бохирдлын шинжилгээ хийж, хог хаягдлын зохистой менежментийг хэрэгжүүлнэ.

1.2.3. “Ногоон Сэлэнгэ” хөдөлгөөнийг эрчимжүүлэн ногоон байгууламжийн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.

1.2.4. Булаг, шанд, горхи, рашааны ундаргын эхийг хамгаалах ажлыг эрчимжүүлж, голын ай сав газрыг бургасжуулах, ойжуулах ажлыг дэс дараатайгаар хэрэгжүүлнэ.

1.2.5. Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах бодлого хэрэгжүүлж, уул уурхайн хайгуул, олборлолтод өртөж, эвдрэлд орсон газар нутгийг нөхөн сэргээнэ.

1.2.6. Түгээмэл тархацтай ашигт малтмал, уул уурхайн зориулалт бүхий ашиглалт, хайгуулын тусгай зөвшөөрөлтэй газрын мэдээллийн санг үүсгэн улсын бүртгэлд хамруулна.

1.2.7. "Аймгийн нутаг дэвсгэрт уул уурхайн талаар баримтлах бодлого"-ыг хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж, бичил уурхай эрхлэгчдийн талаар баримтлах чиглэлийг тодорхойлж хэрэгжүүлнэ.

1.2.8. Ан амьтныг хамгаалах, зүй зохистой ашиглах, эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлнэ.

1.2.9. Байгалийн ургамлын аймгийн нөөц, тархалтын судалгааг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

1.2.10. Газар өмчлөл, эзэмшил, ашиглалттай холбогдсон мэдээллийн ил тод байдлыг хангаж, шинээр газар өмчлүүлэх ажлыг эрчимжүүлж, газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулна.

1.2.11. Аймгийн нутаг дэвсгэрийг бүрэн зурагжуулах, геодезийн нэгдсэн сүлжээг бий болгож, мэдээллийг нийтийн хэрэглээнд нэвтрүүлнэ.

1.2.12. Сумдын газар эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдааны үйл ажиллагааг олон нийтэд ил болгож, цахим биржийн программ хангамжийг нэвтрүүлнэ.

1.2.13. Аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, бүс дагасан үйлчилгээ, бизнесийг хөгжүүлнэ.

1.2.14. "Сэлэнгэ аймгийн 9 бахархал"-ыг тодруулж, түүхт болон байгалийн үзэсгэлэнт газруудыг хамгаалалтанд авч, нийтэд сурталчилна.

1.2.15. Аймгийн төвийн ойролцоо "Сэлэнгэ түмний хийморь" аялал жуулчлалын цогцолборыг аймаг, сумд, аж ахуйн нэгж, байгууллага иргэдийн оролцоотойгоор байгуулна.

1.2.16. Жуулчдад зориулсан мэдээллийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ

1.2.17. "Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратеги төлөвлөгөө" боловсруулан хэрэгжүүлэх, цаг агаарт зориудаар нөлөөлж, хур тундас нэмэгдүүлэх, мөндөр зайлуулах арга, техникийг судалж, турших ажлыг эхлүүлнэ.

1.2.18. Цөлжилт ихээр явагдаж байгаа сумдад мэргэжлийн байгууллагаар судалгаа хийлгэж цөлжилттэй тэмцэх ажлыг эрчимжүүлнэ.

1.2.19. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хилийн цэсийн маргаантай байгаа газруудын асуудлыг бүрэн шийдвэрлэнэ.

1.3. Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний бодлого, шинэчлэлийн хүрээнд:

Сум бүр үйлдвэрлэгч байж, хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан, бүтээгдэхүүний тоо хэмжээг нэмэгдүүлнэ.

1.3.1. "Сум бүрт нэг үйлдвэр-үйлчилгээ" хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг төр, хувийн хэвшлийн хамтарсан хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлнэ.

1.3.2. "Сэлэнгийн брэнд" аймгийн хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж, бүтээгдэхүүний нэр, төрлийг нэмэгдүүлж, дотоод, гадаадын зах зээлд сурталчилан, нийлүүлэх бодлого баримтална.

1.3.3. Төмс, хүнсний ногоо угааж савлах, боловсруулалт хийх үйлдвэрийг Сүхбаатар, Мандал, Сайхан суманд, байгалийн гаралтай жимс жимсгэнэ боловсруулах жижиг үйлдвэр цехийг Хүдэр, Түшиг суманд байгуулна.

1.3.4. Сүхбаатар, Мандал, Сайхан суманд сүүний үйлдвэр, бусад сумдад сүү хөргөх цех байгуулах ажлыг төсөл сонгон шалгаруулах замаар хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

1.3.5. Хусан ойн нөөцийг ашиглах боломжийг судлан тогтоож, Хүдэр сум, Түнхэл, Бугант тосгонд мод боловсруулах, зарим сумдад хуванцар, хог хаягдлыг ашиглан хавтан хийх үйлдвэр байгуулна.

1.3.6. Арьс, шир, ноос, ноолууранд анхан шатны боловсруулалт хийх үйлдвэр цехүүдийг байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

1.3.7. Хөнгөн үйлдвэрийн салбар, худалдаа, үйлчилгээг хөгжүүлэх зорилгоор зөвлөгөө, мэдээлэл, сургалт явуулах "Бизнес мэдээлэл"-ийн төв байгуулна.

1.3.8. Аймгийнхаа баялаг бүтээгчдийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээр төрийн байгууллагын худалдан авалтын хэрэгцээг хангаж, орон нутагт үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлтийг нэмэгдүүлнэ.

1.3.9. Худалдаа, үйлчилгээний салбарын үйлчилгээний чанар, боловсон хүчний чадавхийг сайжруулж, үйлчилгээний соёл, стандарт, эрх үүргийн тухай мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх чиглэлээр сургалт, мэдээллийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

1.3.10. Мандал, Цагааннуур сумдад худалдаа үйлчилгээний нэгдсэн төв байгуулна.

1.4. Хөрөнгө оруулалт, дэд бүтцийн бодлого, шинэчлэлийн хүрээнд:

Хүн амын орон сууц, эрчим хүч, ус хангамж, ариутгах татуургын талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангаж иргэдийн эрүүл орчинд ая тухай амьдрах нөхцлийг тогтвортой сайжруулна

1.4.1. Алтанбулаг, Зүүнбүрэн, Хүдэр, Жавхлант, Орхонтуул, Сант сумд, Түнхэл, Хэрх тосгоны хот төлөвлөлт, газар зохион байгуулалтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Сүхбаатар, Мандал сумын хэсэгчилсэн төлөвлөгөөг боловсруулна.

1.4.2. Зах зээлийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан нийтийн болон амины орон сууцны хороолол барих иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжиж Сүхбаатар, Мандал, Сайхан сумдад 100 айлын, бусад сумдад 25 айлын орон сууц барьж ашиглалтанд оруулна.

1.4.3. Нийтийн орон сууцны орц, дээвэр, подвалийн инженерийн шугам сүлжээний засварын ажлыг тогтмол хийнэ.

1.4.4. Аймгийн төвд 50 МВт-ын хүчин чадал бүхий дулааны цахилгаан станц барьж ашиглалтанд оруулан Сүхбаатар сумын айл өрх, аж ахуйн нэгж байгууллагыг жилийн 4 улиралд хэрэглээний халуун усаар ханган, дулаан хангамжийн чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.4.5. Цахилгаан дамжуулах агаарын шугамыг шинэчилж хүчдэлийн уналттай айл өрх болон шинэ суурьшлын бүсийн эрчим хүчний асуудлыг шийдвэрлэнэ.

1.4.6. Ерөө, Жавхлант, Хушаат, Орхон, Түшиг, Зүүнбүрэн сумдад халаалтын нэгдсэн төв шинээр барьж, Бугант, Түнхэл, Номгон, Хэрх тосгоны халаалтын төвд өргөтгөл хийнэ.

1.4.7.Аймгийн төвийн дулааны станцад технологийн шинэчлэлт хийж, зуухны үнс баригч, цахилгаан шүүлтүүр тавьж, тоосжилт, орчны бохирдлыг арилгана.

1.4.8.Сумдад усан сан, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийг засварлах ажлыг үе шаттайгаар хийнэ.

1.4.9.Шаардлагатай сумдад гүний худаг гаргаж ундны болон бэлчээрийн ус хангамжийн чанар, хүртээмжийг сайжруулж, гэр хорооллын ус түгээгүүрийн худгуудыг төвлөрсөн шугам сүлжээнд холбох, худгийн барилгын засвар үйлчилгээг хийж, хашаажуулна.

1.4.10."Зам, тээврийн сүлжээний стратегийн бодлого"-ын баримт бичиг боловсруулан хэрэгжилтийг зохион байгуулна.

1.4.11.Аймгийн хэмжээнд нийт 330 км хатуу хучилттай болон сайжруулсан зам барих ажлыг эхлүүлнэ.

1.4.12.Зарим сумдын үерийн хамгаалалтын далан, гүүрэнд засвар шинэчлэлт хийж, төмөр замтай огтлолцсон нүхэн гарц гаргана.

1.4.13.Хүдэр, Хушаат сумд, Бугант, Түнхэл тосгодыг шилэн кабельд холбох ажлыг үе шаттайгаар хийж, Сүхбаатар сумын төвийн шилэн кабелийн сүлжээнүүдийг худаг сувагчлалд оруулна.

1.4.14."Манай гудамж - Миний гэр" хөтөлбөр боловсруулж, тохижилт бүтээн байгуулалтын ажил хийнэ.

1.4.15.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, олон нийтийн оролцоог хангана.

1.4.16.Иргэдийн ая тухтай, аюулгүй зорчих нөхцлийг бүрдүүлэн зорчигч болон ачаа тээврийн үйлчилгээг өргөжүүлж, стандартын шаардлагад нийцсэн авто вокзалыг барьж ашиглалтанд оруулна.

1.4.17.Сэлэнгэ дугаартай автомашиныг хураамжаас чөлөөлөх, Мандал сумын Түнхэл тосгонд галт тэрэгний түр зогсолтыг холбогдох байгууллагуудтай хамтарч шийдвэрлэнэ.

1.5.Төсөв, санхүүгийн бодлого, шинэчлэлийн хүрээнд:

Төсвийн төлөвлөлт, зарцуулалт, орон нутгийн хөгжлийн сан, хөрөнгө оруулалтыг оновчтой болгон, төсвийн сахилга бат, шилэн дансны хяналт, ил тод байдлыг эрхэмлэж, иргэдийн үнэт цаасны зах зээлийн талаарх мэдлэгийг дээшлүүлнэ.

1.5.1.Төсөв, орон нутгийн хөрөнгө оруулалт, хөгжлийн сангийн төлөвлөлт, зарцуулалтын хяналтанд олон нийтийн оролцоог хангаж, хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа ажил, үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлнэ.

1.5.2.Татвар төлөгчийн хүрээг өргөтгөж, татвар хураалтыг сайжруулан, орон нутгийн төсвийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.

1.5.3. Санхүүгийн хяналт, дотоод аудитын үйл ажиллагааг эрчимжүүлж, “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт”-ыг хэрэгжүүлэн, төсвийн сахилга батыг сахиулж, зөрчил дутагдалгүй ажиллана.

1.5.4. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлж, төсвийн ил тод байдлыг хангана.

1.5.5. Аймгийн Статистик мэдээ, мэдээллийн үнэн зөв бодит байдал, чанарыг дээшлүүлж, олон нийтэд нээлттэй хүртээмжтэй хүргэнэ.

1.5.6. Зарим сумдад бэлэн мөнгөний АТМ-ыг суурилуулах, үнэт цаасны зах зээлийг орон нутагт эрчимжүүлэх ажлыг зохион байгуулна.

1.5.7. Орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалт, захиран зарцуулалтанд хяналт тавьж, орон нутгийн өмчийн оновчтой удирдлагыг хэрэгжүүлнэ.

Хоёр. ХҮН АМЫН ХӨГЖИЛ-НИЙГМИЙН БОДЛОГО

2.1. Эрүүл мэндийн бодлого, шинэчлэлийн хүрээнд:

Салбарын хүний нөөцийг чадавхижуулан, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, оношилгоо, эмчилгээ, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлнэ.

2.1.1. Эмч, эмнэлгийн ажилтны мэргэшил, ур чадварыг нь дээшлүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах бодлогыг хэрэгжүүлнэ.

2.1.2. Эрүүл мэндийн салбарын ажилтны ёс зүй, хариуцлагыг сайжруулж үр дүнг тооцон ажиллана.

2.1.3. Иргэн бүрийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн үзлэгт хамруулах, алслагдсан айл өрх, малчид, тариаланчдад эрүүл мэндийн явуулын тусламж, үйлчилгээг үзүүлж, хүн амын эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдүүлнэ.

2.1.4. “Эрүүл хүүхэд-Эх орны ирээдүй” уриан дор хүүхэд бүрийг урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулан, эрүүл өсч бойжих нөхцөлийг бүрдүүлнэ.

2.1.5. “Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж, “Эх, нялхсын эндэгдэлгүй аймаг, сум, баг” болох хөдөлгөөн өрнүүлж үр дүнд хүргэнэ.

2.1.6. Хүүхэд, залуучуудын амны хөндийн эрүүл мэндийг хамгаалах ажил үйлчилгээг сайжруулж, шүд цоорох өвчлөлийг бууруулна.

2.1.7. Амьсгалын замаар дамжих халдварт өвчин, улаан бурхан, улаанууд өвчний дархлаажуулалтын хамралтыг сайжруулж, өвчлөлийг бууруулах цогц арга хэмжээ авна.

2.1.8. Элэгний хатуурал, хорт хавдар, элэгний С вирусыг эрт оношлох, эмчлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тандалт судалгаанд тулгуурлан тусгайлан хэрэгжүүлнэ.

2.1.9. Хүний дархлал хомсдлын вирус, дархлалын олдмол хомсдол, бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, Сүрьеэгийн эмнэлэгийг шинээр байгуулж, өвчлөлийг бууруулна.

2.1.10. Зоонозын халдварт өвчин, шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчний байгалийн голомтын болон хүн амын дунд тандалт судалгаа, эрсдлийн үнэлгээг хийж урьдчилан сэргийлэх арга хэмжээг авна.

2.1.11.Зоонозын халдвар судлаач, нян судлаач эмч, мэргэжилтний хангалтыг сайжруулан, тогтвор суурьшилтай ажиллуулж, нян судлалын лабораторийн био аюулгүй ажиллагааны тоног төхөөрөмжийг нэмэгдүүлнэ.

2.1.12.Халдварт өвчний эрсдлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, салбар хоорондын хамтын ажиллагааны “Шуурхай удирдлагын нэгж”-ийг байгуулж, байнгын үйл ажиллагаатай болгоно.

2.1.13.Уламжлалт анагаах ухааныг орчин үеийн анагаах ухааны ололттой хослуулан эмчилгээ, сувилгааны чанар, үр өгөөжийг дээшлүүлнэ.

2.1.14.Зайлшгүй шаардлагатай эмийн хангамж, эм ханган нийлүүлэгчдэд тавих хяналтыг сайжруулж, хүн амд эмийн зохистой зөв хэрэглээг төлөвшүүлэх ажлыг дээшлүүлнэ.

2.1.15.Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл аж төрөх ёс, зан үйлийг төлөвшүүлнэ.

2.1.16.Эрүүл мэндийн байгууллагуудад цахим сүлжээг нэвтрүүлж, үйлчилгээний шуурхай байдлыг хангана.

2.1.17.Аймгийн Нэгдсэн эмнэлэгт эрчимт эмчилгээний тасаг байгуулж, мөн компьютер томографийн аппаратаар хангаж, хэрэглээний халуун устай болгоно.

2.1.18.Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг стандартын шаардлагад нийцсэн барилга, анхан шатны оношилгоо, эмчилгээний багаж, тоног төхөөрөмжөөр хангаж, хувийн хэвшлийн эмнэлэг, лабораториудын үйл ажиллагааг дэмжинэ.

2.1.19.Эрүүл мэндийн байгууллагуудын засвар үйлчилгээ, түргэн тусламжийн техник хэрэгсэл, багаж тоног төхөөрөмж, эхо аппаратаар хангах ажлыг үе шаттайгаар хийнэ.

2.1.20.Эрүүл мэндийн үйлчилгээнд иргэд, иргэний нийгмийн байгууллагын зүгээс тавих хяналт, хариуцлагыг сайжруулах талаар олон улсын байгууллагуудтай хамтран ажиллана.

2.2. Боловсролын бодлого, шинэчлэлийн хүрээнд:

Бүх шатны боловсролын байгууллагуудад сурч боловсрох, хөгжих, ажиллах, амьдрах, эрүүл аюулгүй, ээлтэй орчныг бүрдүүлж, боловсролын үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэнэ.

2.2.1.“Хүүхэд бүр цэцэрлэгт” хөтөлбөр хэрэгжүүлж, алслагдсан болон хүн амын суурьшил ихтэй газарт гэр цэцэрлэг, салбар бүлгүүдийг нээж, цэцэрлэг ажиллуулах байгууллага, иргэний санаачилгыг дэмжинэ.

2.2.2.Боловсролын стандартад суурилсан хөтөлбөрийг хэрэгжүүлэн боловсролын чанар, үр дүнг дээшлүүлнэ.

2.2.3.Сургууль, цэцэрлэгт эрүүл ахуй, ариун цэврийн норм, шаардлагыг хангасан, хүүхдэд ээлтэй, аюулгүй орчинг бүрдүүлнэ.

2.2.4.Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдүүдэд сургалтын таатай орчинг бий болгон тэдний нийгмийн хамгааллыг сайжруулна.

2.2.5.Сонгон, секц, дугуйлангаар хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлж, төлөвшүүлэх үйлсийг санаачилсан, амжилт гаргасан багш, иргэн, байгууллагыг хөхиүлэн дэмжинэ.

2.2.6.Сургуулийн дотуур байрны эрүүл, аюулгүй орчин нөхцлийг сайжруулж, хүүхдэд зориулсан асаргаа, халамж, хөгжлийн үйлчилгээтэй болгоно.

2.2.7. Насан туршийн боловсролын иргэдэд өгөх үр нөлөөг дээшлүүлэн нэгжүүдийн сургалтын орчинг сайжруулж, багшлах боловсон хүчний чадавхийг дээшлүүлнэ.

2.2.8. "Багш, сурагч солилцоо" хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ.

2.2.9. Сургууль, цэцэрлэгүүдийн цахим орчинг сайжруулж, "SMART" буюу ухаалаг сургалтын технологийг нэвтрүүлнэ.

2.2.10. Ерөнхий боловсролын зарим сургуулиудад стандартын шаардлага хангасан кабинетуудыг байгуулна.

2.2.11. Үдийн цай болон дотуур байр, цэцэрлэгүүдэд хэрэглэгдэх хүнсний бүтээгдэхүүний чанарт тавих хяналтыг сайжруулж, бүх сургууль, цэцэрлэгийг "Эрүүл мэндийг дэмжигч" сургууль, цэцэрлэг болох хөдөлгөөнд хамруулж, үр дүнг тооцдог болно.

2.2.12. Сургууль, цэцэрлэгийг хүнсний ногооны хүлэмж, байгалийн ухааны хичээлийн туршилтын талбайтай болгож, хүүхдэд хөдөлмөрийн дадлага олгох нөхцлийг бүрдүүлнэ.

2.2.13. Аймагтаа дээд боловсрол эзэмших боломжийг бүрдүүлнэ.

2.2.14. Зорилтот бүлгийн амжилттай суралцаж байгаа оюутнуудыг дэмжих бодлого баримталж, их, дээд сургуулийн сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлнэ.

2.2.15. Боловсролын үйлчилгээнд иргэд, иргэний нийгмийн байгууллагын зүгээс тавих хяналт, хариуцлагыг сайжруулах талаар олон улсын байгууллагуудтай хамтран ажиллана.

2.3 Биеийн тамир, спортын бодлого, шинэчлэлийн хүрээнд:

Нийтийн биеийн тамир, спортын хүний нөөц, дэд бүтцийг сайжруулж, үндэсний спортын өв соёлыг уламжлуулан нийтийн хүртээл болгох, иргэдийг хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

2.3.1. Биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн арга зүйч, багш, дасгалжуулагчдыг мэргэшүүлэх, мэдлэг, ур чадварыг дээшлүүлнэ.

2.3.2. Зарим сумдад спорт цогцолбор, спорт заал, наадмын талбайг шинээр барьж байгуулан шаардлагатай эд материал, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангана.

2.3.3. Аймгийн төв, сумдад цанын бааз, тэшүүрийн талбай байгуулж, өвлийн спорт, амралт зугаалгын орчинг сайжруулна.

2.3.4. Сум, тосгон, багийн төвд спортын талбайг төрөлжүүлэн байгуулж, гэрэлтүүлэг, орчны тохижилтын ажлыг хийнэ.

2.3.5. Үндэсний сур, бөх, шагайн харвааны аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг жил бүр зохион байгуулж, үндэсний спортын соёлыг өвлүүлэн уламжлуулах ажилд ахиц гаргана.

2.3.6. "Сэлэнгэ-түмэн" арга хэмжээг Улаанбаатар хотод зохион байгуулж, аймгаа сурталчилна.

2.3.7. Өсвөр үеийн аймгийн шигшээ багийн спортын төрлийг нэмэгдүүлж, ур чадварыг дээшлүүлнэ.

2.3.8. "Сэлэнгэ-бага олимп" спортын олон төрөлт арга хэмжээг 2 жил тутам зохион байгуулна.

2.3.9.Спортын зарим төрлүүдээр улсын болон бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг аймагтаа зохион байгуулна.

2.3.10.Спортын мэргэжлийн холбоо, клубуудын үйл ажиллагааг дэмжинэ.

2.3.11."Зохистой хөдөлгөөн-Эрүүл мэнд" аяныг аймгийн хэмжээнд өрнүүлж, иог, бясалгал, нийтийн бүжиг, бялдаржуулах урлагийг хөгжүүлнэ.

2.4. Соёл, урлагийн бодлого, шинэчлэлийн хүрээнд:

Үндэсний өв соёлыг хөгжүүлэх, өвлөн уламжлах, сурталчлах, соёл урлагийн аялал жуулчлал, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.4.1.Соёл, урлагийн байгууллагуудыг мэргэжлийн боловсон хүчнээр хангах, чадавхижуулах, уран бүтээлчдийг урамшуулах бодлого хэрэгжүүлнэ.

2.4.2.Соёл, урлагийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, гадаад, дотоодод үндэсний соёл урлагийг сурталчлах, бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгоно.

2.4.3.Сэлэнгэ аймгийн бахархал, түүхийн сэдэвтэй кино, тайз, дэлгэц, утга зохиолын томоохон хэмжээний мэргэжлийн түвшний бүтээл туурвихад дэмжлэг үзүүлнэ.

2.4.4.Музейн үзмэрийн соёлын үнэт зүйлс, биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулж олон улсын стандартад хүргэнэ.

2.4.5.Аймаг, сум, сургуулийн номын сангийн нөөцийг үндэсний болон дэлхийн сонгодог уран зохиолын номуудаар баяжуулж, үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлнэ.

2.4.6."Урлагийн их наадам", "Эв модны наадам" зэрэг урлаг, соёлын арга хэмжээнүүдийн хамрах хүрээг нэмэгдүүлэн зохион байгуулна.

2.4.7."Өргөн Сэлэнгэ" зохиолын шинэ дууны уралдааныг улсын хэмжээнд зохион байгуулна.

2.4.8."Бид Партизаны үр сад" арга хэмжээг зохион байгуулж, түүхэн хүмүүсийн тухай ном, товхимол гаргана.

2.4.9.Түүх соёлын дурсгалт зүйлсийг шинээр барих сэргээн засварлах ажлыг үе шаттай зохион байгуулна.

2.4.10.Зарим сумдын соёлын төвийн барилгыг засварлах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

2.5. Гэр бүл, эмэгтэйчүүд, хүүхэд, залуучуудын бодлого, шинэчлэлийн хүрээнд:

Гэр бүлийн үнэт зүйлсийг бэхжүүлж, төрөлх нутгаараа бахархах, түүх, ёс заншил, уламжлалт соёлоо дээдлэх, амьдралын арга ухаанд сургах замаар өрсөлдөх чадвартай, хөдөлмөрч, хүмүүнлэг иргэнийг төлөвшүүлнэ.

2.5.1.Аймаг, сумынхаа түүх, соёл, уламжлалыг мэддэг, хөдөлмөрт дуртай, нутаг орноороо бахархах үзэл хүмүүжилтэй, амьдралын зөв дадал хэвшилтэй, боловсролтой иргэн болгон төлөвшүүлэх, гэр бүлийн хөгжлийг дэмжих "Бид Сэлэнгийн ирээдүй", "Жаргалтай гэр бүл", "Залууст боломж" хөтөлбөрүүдийг боловсруулж хэрэгжүүлнэ.

2.5.2.Хүүхдийн хүнд хөдөлмөр эрхлэх, осол гэмтлээс сэргийлэх талаар сургууль, цэцэрлэг, эцэг эхийн хариуцлагыг өндөржүүлж бүртгэл, мэдээллийг сайжруулна.

2.5.3.Хүүхдийн хөгжил хамгааллын салбар дундын зохицуулалтыг бэхжүүлж “Хүүхдэд ээлтэй бодлого”-ыг баримталж ажиллана.

2.5.4.Хүүхдийн эрхийн хэрэгжилтэнд баг, сумаас тавих хяналтыг сайжруулж, гэмт хэрэг, хүчирхийлэл, болзошгүй эрсдлээс хамгаалж, эрхийн зөрчилгүй болно.

2.5.5.Хүүхэд, залуучуудын хөгжих, мэдлэг, чадвараа дээшлүүлэх, туршлага солилцох, эрх ашгийг хамгаалахад чиглэсэн клуб, холбоод төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжинэ.

2.5.6.Хүүхэд багачуудын авьяас чадварыг нээн хөгжүүлэх “Бид Сэлэнгийн үр сад”, “Дунгийн эгшиг” урлаг, соёлын арга хэмжээг зохион байгуулна.

2.5.7.Хүүхдийн зуслан, хөдөлмөр амралтын зуслан ажиллуулж, гадаадын улс орнуудтай хүүхэд солилцон амраах нөхцлийг бүрдүүлнэ.

2.5.8.Гадаад улсад суралцаж, ажиллаж байсан залуучуудын мэдлэг туршлагыг хуваалцах “Бид эх нутагтаа” уулзалтыг 2 жил тутам зохион байгуулна.

2.5.9.Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийлэлд өртөгсдийг хамгаалах ажлыг сайжруулна.

2.5.10.Аймгийн төвд “Гэр бүлийн ордон”, сумдад “Гэр бүлийн төв” ажиллуулж, иргэдийн мэдлэг чадвараа дээшлүүлэх, туршлага солилцох, амьдрах ухааны сургалт зохион байгуулах, бүтээлийн үзэсгэлэн гаргах зэрэг гэр бүлийн хөгжлийн олон талт арга хэмжээг тогтмол явуулна.

2.6. Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын бодлого, шинэчлэлийн хүрээнд:

Зах зээлийн эрэлтэд нийцсэн үр чадвар, мэргэшилтэй ажилтнуудыг бэлтгэх, шинээр ажлын байр бий болгох замаар өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.

2.6.1.Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчийн захиалгыг үндэслэн, мэргэжилтэй ажилтан бэлтгэж, байнгын ажлын байрыг нэмэгдүүлнэ.

2.6.2.Хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл, цахим мэдээллийн санг өргөжүүлэх, иргэдэд үзүүлэх хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлж, ажилгүй иргэдийг ажилд зуучилна.

2.6.3.Төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар 4000-аас доошгүй шинэ ажлын байр бий болгоно.

2.6.4.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл орчныг сайжруулах аймгийн дэд хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлнэ.

2.6.5.Мэргэжлийн боловсрол сургалтын төвүүдийн багш, ажилтны мэдлэг, чадварыг дээшлүүлж, сургалтын чанар, үр өгөөжийг сайжруулна.

2.6.6.Хүүхэд, залууст ажлын дадлага, туршлага, мэргэжлийн үр чадварыг дээшлүүлэх, дадлагажуулах “Ахмадын зөвлөх үйлчилгээ”-г бий болгоно.

2.6.7.Ахмад настны амралт, чөлөөт цагийн клуб, эмчилгээ, сувилгааны төвийн үйл ажиллагааг дэмжиж, ахмадуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулна.

2.6.8.70-аас дээш насны ахмадууд эмнэлэгт үзүүлэх, шинжилгээ хийлгэх, хэвтэж эмчлүүлэхэд дугаар харгалзахгүй үйлчлэх "Хүндлэл" үйлчилгээг бий болгоно.

2.6.9.Ахмад настны асаргаа үйлчилгээ, сэргээн засах болон сувилахуйн үйлчилгээг өргөжүүлнэ.

2.6.10.Ойжуулалт, цэцэрлэгжүүлэлт, туслах аж ахуй эрхлэх, хүүхэд асрах, байгаль орчныг хамгаалах зэрэг олон нийтэд тустай ажил үйлчилгээг эрхлэх ахмадуудын санал, санаачилгыг дэмжинэ.

2.6.11. Айл өрх бүрээс 1-ээс доошгүй хүн, мөн 40-өөс дээш насны иргэн ажилтай байх хөдөлмөр эрхлэлтийн шинэ бодлогыг хэрэгжүүлнэ.

2.6.12.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.

2.6.13.Харьцангуй бага орлоготой айл өрхийг туслах аж ахуй эрхлүүлэх замаар ажлын байр, амьжиргааны эх үүсвэртэй болгоно.

2.6.14.Өрхийн амьжиргааны түвшинг тогтоох судалгаанд үндэслэн зорилтот бүлгийг оновчтой тодорхойлж, тэдэнд чиглэсэн нийгмийн халамжийн бодлогыг шуурхай, үр дүнтэй хэрэгжүүлнэ.

2.6.15.Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд ажилгүй иргэн, малчин, бичил уурхай эрхлэгчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг хамруулна.

2.6.16.Эрүүл мэндийн даатгалын сангаас иргэдэд олгодог эмийн үнийн хөнгөлөлтийн төсвийг 30 хүртэл хувиар нэмэгдүүлж, хөнгөлөлттэй үнээр үйлчилнэ.

Гурав.ИРГЭДИЙН ОРОЛЦОО-ИЛ ТОД, ХАРИУЦЛАГАТАЙ ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО:

3.1 Төрийн удирдлагын бодлого, шинэчлэлийн хүрээнд:

Нутгийн захиргааны байгууллагуудын ажил үйлчилгээнд дэвшилтэт технологийг нэвтрүүлж, төрийн үйлчилгээний ил тод байдлыг ханган, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

3.1.1.Төр, төсвийн байгууллагуудад "Соёлтой харилцаа-Шуурхай үйлчилгээ" хөдөлгөөнийг өрнүүлж, иргэнээ дээдэлсэн төрийн үйлчилгээг төлөвшүүлнэ.

3.1.2.Технологийн дэвшлийг ашиглан иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх ажил, үйлчилгээнд шинэчлэл хийж, "Нээлттэй Сэлэнгэ" төрийн үйлчилгээний цахим лавлахыг хэрэглээнд нэвтрүүлнэ.

3.1.3."Төрийн үйлчилгээний нэгдсэн төв"-ийн үйл ажиллагааны хүрээг өргөтгөж, "ТҮЦ" машиныг зарим сумдад байршуулж, үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ.

3.1.4."Багийн хөгжлийн хөтөлбөр"-ийг боловсруулан хэрэгжүүлж, "Тэргүүний тосгон, баг" шалгаруулж, урамшуулах замаар багуудын ажиллах орчин нөхцлийг сайжруулан, зарим баг \тосгон\-ийг сум болгох асуудлыг холбогдох дээд шатны байгууллагад уламжилна.

3.1.5.Төрийн албаны стандартыг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж, нээлттэй өрсөлдөөний зарчмыг баримтлан гүйцэтгэлийн удирдлагыг хангана.

3.1.6. "Суралцагч байгууллага-Төрийн албаны манлайлал", "Нийгмийн баталгаа" хөтөлбөрийг шинэчлэн хэрэгжүүлж, төрийн албаны тогтвортой байдлыг хангаж, удирдлагын манлайллыг дээшлүүлнэ.

3.1.7. Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015 стандартыг зарим сум, байгууллагад хэрэгжүүлэх санал, санаачилгыг дэмжиж, "Үндэсний чанарын хөтөлбөр"-ийг хэрэгжүүлнэ.

3.1.8. Аймаг, сумдын цахим хуудсыг шинэчлэн мэдээллийн баяжилтыг тогтмолжуулж, иргэдийг аймаг, орон нутгийн мэдээ, мэдээллээр шуурхай хангана.

3.1.9. Аймаг орон нутгийн онцлог, нийгэм, эдийн засгийн дэвшлийг хэвлэл мэдээллийн байгууллагуудаар сурталчилж, "Өргөн Сэлэнгэ" сэтгүүл, "Сэлэнгийн өнгө" нэвтрүүлгийг нийтийн хүртээл болгоно.

3.1.10. Орон нутгийн мэдээллийн байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлж, "Хэвлэл мэдээллийн сүлжээ"-г бий болгон, мэргэжлийн "Мэдээллийн студи" ажиллуулна.

3.1.11. "Түүхийн он дарааллын бичээс" эмхэтгэлийг жил бүр гаргаж олон нийтийн хүртээл болгох ажлыг үргэлжлүүлнэ.

3.1.12. Бодлого төлөвлөлт, боловсруулалт, хэрэгжүүлэлтийн үе шат бүрт иргэдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлж, үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог бэхжүүлнэ.

3.1.13. Төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд үйлчилгээний давхардал, чанаргүй ажил үйлчилгээ, үр ашиггүй зардлыг багасгаж, дотоод аудитын үр нөлөөг сайжруулна.

3.1.14. Иргэдийн санал, хүсэлтэд тулгуурлан үйлчилгээний чанарын хяналт-шинжилгээ, үнэлгээг шаардлагатай төр, төсвийн байгууллагуудад тухай бүр зохион байгуулж эерэг үр дүнд хүргэнэ.

3.1.15. Сэлэнгэчүүдийнхээ хөдөлмөрийг үнэлэн, гавъяат үйлстнүүдээ мөнхлөн алдаршуулах зорилгоор Сэлэнгэ аймгийн алдартнуудын нэрэмжит шагнал бий болгоно.

3.1.16. Аймгийн 90 жилийн ойн арга хэмжээг угтсан "Сэлэнгэ шинэ бүтээн байгуулалт" хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ.

3.1.17. "Орон нутгийн цогц-хөгжил" төслийг хэрэгжүүлж, орон нутгийн хөгжилд Төр, Иргэний нийгмийн байгууллага, Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, Уул уурхайн байгууллагын түншлэлийн тэгш оролцоог хангаж, төрийн зарим чиг үүргийг иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлнэ.

3.1.18. Орон нутгийн хөгжилд үр өгөөжтэй гадаад харилцааны хүрээг өргөтгөж, шинэ түншлэлийн нээлттэй бодлого баримтлан, гадаад харилцааг эдийн засагжуулах хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.

3.1.19. Монгол-Оросын хил орчмын бүс нутгийн засаг захиргаа, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн харилцан ашигтай хамтын ажиллагааг бүх талаар өргөжүүлнэ.

3.1.20. Зүүн хойд Азийн бүс нутгийн Засаг захиргаадын холбооны үйл ажиллагаанд идэвх санаачлагатай оролцож, аймаг орон нутгаа олон улсын түвшинд сурталчлах үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

3.1.21. Алтанбулаг-Хиагт, Сүхбаатар-Наушкийн олон улсын хилийн боомтуудын шалган нэвтрүүлэх байгууллагуудын үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлэх

нөхцлийг бүрдүүлж, Алтанбулаг хилийн боомтоор зорчиж байгаа иргэдийг ая тухтай орчин нөхцлөөр үйлчлүүлэх боломжийг хангана.

3.1.22.Хэмжилзүйн байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж шатахуун түгээгүүрийг баталгаажуулах зориулалтын хэмжих хэрэгсэл бүхий автомашинаар хангахад дэмжлэг үзүүлнэ.

3.1.23.Хэрэглэгчийн эрхийг хамгаалах, зөрчихөөс урьдчилан сэргийлэх, хэрэглэгчийг мэдээ мэдээллээр хангах зорилго бүхий “Хэрэглэгчийн төв”-ийг байгуулж, үйл ажиллагааг жигдрүүлнэ.

3.1.24.Мэргэжлийн хяналтын ажил үйлчилгээг иргэд, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн оновчтой арга хэлбэрт шилжүүлж, эрсдэлд суурилсан хяналтыг явуулж, зөвлөн туслах чиглэлийг баримтлан ажиллана.

3.1.25.Гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэл, эмзэг байдлыг бууруулах, сэрэмжлүүлэх үйл ажиллагаанд бүх нийтийн оролцоо, мэргэжлийн байгууллагын бэлэн байдлыг хангаж, гамшигтай тэмцэх чадавхийг бэхжүүлнэ.

3.1.26.Батлан хамгаалах хууль, тогтоомж, бодлого, үйл ажиллагааг сурталчлан хэрэгжүүлж, цэргийн насны залуучуудын эрүүл мэнд, боловсролын түвшинг дээшлүүлэн цэрэг эх оронч үндэсний үзлийг төлөвшүүлэх зорилгоор ахлах ангийн сурагчдын дунд цэрэгжилт спортын “ДӨЛ” тоглолтыг зохион байгуулна.

3.2 Хууль эрх зүй, хүний эрхийг хангах бодлого, шинэчлэлийн хүрээнд:

Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, хүний эрхийг хангах олон талт арга хэмжээг хэрэгжүүлж, хуулийн хэрэгжилтийг чанд мөрдүүлэх замаар гэмт хэргийн гаралтыг бууруулан, иргэдийн аюулгүй амьдрах орчин нөхцлийг бүрдүүлнэ.

3.2.1.“Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр” боловсруулан хэрэгжүүлж, нийгмийн зорилтот бүлгийн иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх үйлчилгээг өргөжүүлнэ.

3.2.2.Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангаж захиргааны байгууллагуудаас иргэдийн эрхийг аливаа хэлбэрээр зөрчихгүй байх нөхцлийг бүрдүүлнэ.

3.2.3.Хууль, эрх зүйн актын болон бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтэд тавих гүйцэтгэлийн хяналтыг сайжруулна.

3.2.4.“Авлигатай тэмцэх, хариуцлага, шударга ёсыг бэхжүүлэх аймгийн хөтөлбөр”-ийг боловсруулан хэрэгжүүлж, “Авлига ашиг сонирхолын зөрчилгүй байгууллага, хамт олон болох” хөдөлгөөнийг өрнүүлнэ.

3.2.5.Хүний эрхийг хангах, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ.

3.2.6.Төрийн болон байгууллагын архивын цаасан суурьтай баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг эрчимжүүлж, төрийн архивыг зориулалтын байртай болгоно.

3.2.7.Улсын бүртгэлийн ажил үйлчилгээний шуурхай байдлыг хангаж, бүртгэлийн үйлчилгээг чирэгдэлгүй хүргэх боломж нөхцлийг бүрдүүлнэ.

3.2.8.Хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааг ил тод, нээлттэй, иргэдэд чирэгдэлгүй, тэгш шударга, ялгаваргүй үйлчлэх нөхцлийг бүрдүүлж,

эрсдлийг бууруулах замаар үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг дээшлүүлэн, хуульд заасан үүргээ стандартын дагуу хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

3.2.9.Хууль сахиулах байгууллагуудын ажлын уялдаа, хамтын ажиллагаа, үүрэг гүйцэтгэх дадлага, арга зүйг дээшлүүлэх "Команд штабын сургууль"-ийг зохион байгуулна.

3.2.10.Хил хамгаалах албыг бэхжүүлж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

3.2.11."Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр"-ийг боловсруулж, хэрэгжүүлнэ.

3.2.12."Хүүхдийг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх эргүүл хяналтын ажилд сурагчдын эцэг эхийг ажиллуулах журам"-ыг боловсруулан хэрэгжүүлж, иргэд, олон нийтийн оролцоотойгоор зохион байгуулна.

3.2.13.Гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах хамгаалах байрыг зарим сумдад бий болгоно.

3.2.14."Архидалттай тэмцэх аймгийн хөтөлбөр"-ийг үр дүнтэй хэрэгжүүлж, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн тоог бууруулна.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР